## ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭМЭЛТ ТӨСВИЙН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагч
Төсвийн байгууллага
Нэмэлт төсвийн дансны дугаар

| № | Санхүүжилт өгсөн байгууллага, төслийн нэр / Төсвийн байгууллагын нэр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Санхүүжсэн эх үүсвэр | | Эцсийн үлдэгдэл | Татан төвлөрүүлсэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн болон нутгийн өмчит бус эигээдээс авсан хандив тусламж | Нийт гүйцэтгэл | | Төвлөрүүлсэн |
| | | | | | 2 | 11 | 12 | 13 |
| 1 | АНУ Флоридагийн их сургууль, Монгол орны хачгаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтыг тогтоох судалгааны ажил | 2025.03.01-2025.08.30 | Монгол орны түгээмэл тархсан бэлчээрийн хачигнад хачгаар дамжих зарим халдварын молекул биологийн шинжилгээ хийх. | Төсөл хөтөлбөр 100% хэрэгжсэн. Монгол улсад тархсан зарим зүйлийн иксод хачгийн тархалт болон хачгаар дамжих халдварын үүсгэгчдийн хэв шинж, тархалтыг судлах ажлын хүрээнд Монгол орны зарим аймгийн нутаг дэвсгэрээс бэлчээрийн хачиг цуглуулж, зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хачгаар дамжих халдварын үүсгэгчдийг тодорхойлсон. | 43,416,250.00 | 43,416,250.00 | - | - |
| 2 | ДЭМБ, Монгол орны уйланхайт бэтэг өвчний эмнэлзүйн удирдамжийг сайжруулах болон нэг эрүүл мэнд зарчимд уялдуулах нь | 2025.01.01-2025.06.30 | ДЭМБ-ын зөвлөж буй зааврын (WHO-IWGE) хэрэгжилт, бодит хэрэглээний талаар эмч мэргэжилтнүүдийн санал бодлыг тусгасан үнэлгээ гарна. | Улианхайт бэтгийн мэс заслын тохиолдлын тоог 2016-2023 оны тоо мэдээнд тулгуурлаж гаргаж, өмнөх 2008-2015 онд хийгдсэн суурь судалгаатай харьцуулсан дүн гаргасан. 4:15 жилийн тоон мэдээнд (2008-2023) үндэслэж бэтгийн халдварын эрсдэл өндөр байгаа газрыг тогтоож, цаашид халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг “Нэг Эрүүл Мэнд” зарчмын хүрээнд хэрхэн өрнүүлэх болон хүндрэлээс сэргийлэх талаар зөвлөмж боловсруулав. | 2,531,812.50 | 2,531,812.50 | - | - |
| 3 | ДЭМБ, МУ-д тохиолдож болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийн үнэлгээ хийх, холбогдох баримт бичиг боловсруулах | 2025.04.01-2025.08.31 | Монгол улсад тохиолдож болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхын үнэлгээ хийх, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, гамшгаас хамгаалах тухай хууль болон олон улсын эрүүл мэндийн дүрэм, гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ болон бусад холбогдох эрх зүйн баримт бичигтэй уялдуулан нэгдсэн стратеги төлөвлөгөө, эрсдэлийн зураглал зэрэг холбогдох баримт бичгийн боловсруулна. | Төсөл хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн. “Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх монгол улсын чадавхыг нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 10 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, 7 төрлийн 66 лабораторийн тоног төхөөрөмжийг захиалж, ЗӨСҮТ-ийн лабораторийн засварыг хийгээд байна. | 152,709,040.00 | 152,709,040.00 | - | - |
| 4 | ДЭМБ, Орон нутгийн онцлогт тохирсон нутагшмал зоонозын тэргүүлэх өвчний жагсаалтыг гаргах, тандалт, оношилгооны тулгамдсан асуудлыг тодорхойлох | 2025.04.01-2025.08.30 | Орон нутаг бүрийн байгалийн голомтын онцлогт тохирсон нутагшмал зоонозын тэргүүлэх өвчний жагсаалт, эдгээрийг оношлоход шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, чанар биоаюулгүй ажиллагаа, био хамгааллын чиглэлээр хийх ажлын хэрэгцээ, шаардлага тодорхойлно. | Төсөл хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн. Орон нутгийн зоонозын тэргүүлэх өвчний тандалт, оношилгооны чиглэлээр орхигдсон асуудлыг тодорхойлох хэлэлцүүлэг зохион байгуулсан. Орон нутаг бүрийн байгалийн голомтот онцлогт тохирсон нутагшмал зооноз тэргүүлэх өвчний чиглэлээр хийх тандалт судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулсан. Зоонозын 30 гаруй өвчний чиглэлээр FACT sheet боловсруулсан. | 52,196,000.00 | 52,196,000.00 | - | - |

2024 онд хэрэгүүлсэн төсөл хөтөлбөрийн үлдэгдэл

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | ДЭМБ, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ дадлага сургуулилалт хийх | 2025.05.01-2025.07.31 | Сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд шинэ мэдлэг олж авч чадсан байна. Эмнэлгийн яаралтай тусламжийн баг хүч хэрэгслийг нэмэлтээр шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан байна. Дадлага сургуулилтаас гарсан үр дүн, дүгнэлтийг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөмжөөр хүргүүлсэн байна. | Дадлага сургуулилтанд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, ОБЕГ-аас 190 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтэн албан хаагчид оролцож болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой бэлэн байдлын үед үндэсний бэлэн байдлыг хангах зорилгоор хүч хэрэгслийн анх удаа дэлгэн дасгал сургуулилт хийж, стандарт үйл ажиллагааны журамд нийцүүлэн, сайжруулсан. | 92,787,100.00 | 92,787,100.00 | - | - |
| 6 | ДЭМБ, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааны стандарт журам болон виртуал сургуулилалтын хөтөлбөр боловсруулах | 2025.04.01-2025.08.30 | Батлагдсан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааны стандарт журам болон боловсруулсан виртуал сургалтыг хөтөлбөр боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна. | Төсөл хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн. Дэлхийн улс орны сайн туршлагыг судлан шаардлагатай гарын авлага боловсруулсан. Мөн Монгол улсын халдварт өвчний нөхцөл байдалд уялдуулсан нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад эрүүл мэндийн мэргэжилтнийг тасралтгүй сургах, үйл ажиллагаанд виртуал сургалтын хөтөлбөрийн зохиомж боловсруулан, видео бичлэг болон зураг хэлбэрээр хийж мэргэжилтнүүдийг чадавхжуулсан. Үүнд 35-40 орчим эрүүл мэндийн ажилтан оролцсон. | 37,350,000.00 | 37,350,000.00 | - | - |
| 7 | НҮБХС, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн харъяа нийслэл, аймгийн ЗӨСТөвүүдэд чанар, тусламж үйлчилгээ, үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх | 2025.04.01-2025.12.31 | Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн харъяа нийслэл, аймгийн ЗӨСТөвүүдэд чанар, тусламж үйлчилгээ, үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх. Үнэлгээний дүнд нийслэл, орон нутгийн харьяа зоонозын өвчин судлалын төвүүдэд стандарт шаардлагын дагуу сайжруулах хэрэгцээ шаардлагыг гаргаж, шийдвэр гаргагч нарт танилцуулна. Батлагдсан удирдамжийн дагуу хийсэн дэмжлэгт хяналтын шалгуур хуудаснуудыг нэгтгэх, нэгдсэн зөвлөмж бичиж эргэн мэдээлэх, тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг шийдвэрлүүлэх. | Төсөл хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн. Орон нутгийн 14 Зоонозын өвчин судлалын төвүүдэд MNS ISO 15189:2024, 17025:2018 . MNS ISO 5766:2021, 5765:2021 Лабораторийн стандарт шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ, дүгнэлт өгөв. Төвийн захирлын 2023 оны А/35 тоот тушаалын дагуу ЗӨСТүүдийн үйл ажиллагааны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн хуудаснууд, шалгуур үзүүлэлт бүхий үнэлгээний хуудсаар үнэлж байгууллагын үйл ажиллагаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний аюулгүй байдалд хяналт хийж ажиллав, Шалгуур үзүүлэлт тус бүрт үнэлгээ дүгнэлт өгсний дараа илэрсэн тохиолдлыг арилгах зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэн чанар стандартыг сайжруулан ажилласан. | 70,575,770.00 | 70,575,770.00 | - | - |
| 8 | НҮБХС, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 9001:2015 стандартын сургалт, үнэлгээ хийх | 2025.06.01-2025.12.31 | ЗӨСҮТөвд олон улсын чанарын менежментийн тогтолцоонд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхийн өмнөх гарааны дүн шинжилгээ хийж, түүний дагуу стандартын шаардлагад нийцүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргагч нарт танилцуулах. | 100% хэрэгжсэн. Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төвд олон улсын чанарын менежментийн тогтолцоонд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхийн өмнөх бэлтгэл ажлыг эхлүүлж, одоогийн чанарын менежментийн тогтолцоонд дүн шинжилгээ хийсэн. ISO 9001:2015 стандартын шаардлагуудын дагуу зөрүүний шинжилгээ хийж. Байгууллагын одоо ашиглаж байгаа ЧМТ-нд хамаарах баримт бичигт дүн шинжилгээ хийсэн. ISO 9001:2015 стандартын шаардлагын дагуу баримтжуулсан мэдээллүүдийг сайжруулах болон шинээр боловсруулах хэрэгцээг тодорхойлов. Дүн шинжилгээний тайланг үндэслэн, төслийн нарийвчилсан төлөвлөгөөг удирдлагын багтай хамтран боловсруулсан.Удирдлагын багт ISO 9001:2015 стандартын танилцуулга, манлайллын сургалтыг явуулж ажиллав. | 144,000,000.00 | 144,000,000.00 | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | НҮБХС, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд MNS ISO/IEC 17025:2018 сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага, холбогдох баримт бичиг боловсруулах | 2025.06.01-2025.12.32 | Зоонозын сүлжээ лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандарт, итгэмжлэлийн тогтолцооны эрхзүйн орчны талаар мэдлэг эзэмшсэн хүний нөөц бүрдэнэ. Зоонозын сүлжээ лабораторийн чанарын удирдлагын тогтолцоонд баримтлах шинжилгээний стандарт ажлын заавар, анхан шатны бүртгэл маягтыг боловсруулах хэрэгжүүлсэн байна. | 100% хэрэгжсэн. Үндэсний итгэмжлэлийн төвтэй хамтран "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 17025:2018" стандартын тайлбар сургалтыг зохион байгуулсан. Зоонозын сүлжээ лабораторид баримтлах шинжилгээний заавар боловсруулж хянасан. Шинэчлэн, боловсруулсан анхан шатны бүртгэл маягтыг нэгтгэн хэвлэж зоонозын сүлжээ лабораториудад түгээж шинэчилсэн. | 130,114,000.00 | 130,114,000.00 | - | - |
| 10 | ДЭМБ, Yersinia-15 Олон улсын симпиозумыг зохион байгуулах | 2025.06.01-2025.10.31 | Тарваган тахал болон зоонозын бусад халдварууды үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хянахад олон улсын хэмжээнд нэг эрүүл мэнд үзэл баримтлалын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах хүн эмнэлэг, мал эмнэлэг болон байгаль орчны салбарын байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл тодорхойлогдсон байна. Мөн орон нутгийн болон үндэсний төвийн мэргэжилтэнүүдэд тарваган тахал болон зоонозын бусад халдварын чиглэлээр сүүлийн үеийн шинэлэг мэдээллээр хангагдаж, судалгааны арга зүйн хувьд чадавхжсан байна. | Төсөл хөтөлбөр 100% хэрэгжсэн. Дэлхийн 12 орны 200 орчим судлаачид оролцож, өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, сүүлийн үеийн томоохон туршилт, судалгааны үр дүнг танилцуулахын зэрэгцээ цаашдын хамтын ажиллагаа, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний тухайд мөн санал солилцсон нь Монгол улс зоонозын халдварууд, ялангуяа тарваган тахал өвчний өндөр эрсдэлтэй бүс нутаг учраас хүн амыг эдгээр халдвараас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг сайжруулах, мэргэжлийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. | 112,641,900.00 | 112,641,900.00 | - | - |
| 11 | ДЭМБ, ЭМЯ, ХХААЯ, БОАЖЯ-ны хамтарсан тушаалаар батлуулсан дунд хугацааны нэг эрүүл мэнд төлөвлөгөө боловсруулах | 2025.08.01-2025.12.31 | Эрүүл мэндийн яам, мал эмнэлэг, байгаль орчны асуудал хариуцсан 3Г-ын гишүүдийн хамтарсан "Нэг эрүүл мэнд" зөвлөлийн тушаал, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана. | Төсөл хөтөлбөр 76.3% хэрэгжсэн. 23.7 хувийг ДЭМБ-д буцаан олгосон. Нэг эрүүл мэнд зарчмыг хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт үнэлгээ хийсэн. Салбар хорооны ажлын хэсэг байгуулж хэлэлцүүлэг хийсэн. Нэг эрүүл мэнд зөвлөлийн болон хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг 3 сайдын хамтарсан тушаалаар батлуулсан. Салбар хоорондын хамтарсан судалгааг хийсэн. | 257,673,840.00 | 196,704,000.00 | 60,969,840.00 | - |
| 12 | НҮБХС, Зоонозын өвчний тандалтын системийг сайжруулахад зайнаас тандан судлалын технологи ашиглах арга зүйд суралцах нь сургалт үнэлгээ хийх | 2025.08.01-2025.12.31 | Зайнаас тандан судлалын технологи ашиглах арга зүйг онол, практик хослуулан хиймэл дагуулын мэдээ ашиглалт, түүнд боловсруулалт хийх, сэдэвчилсэн зураг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн бий болгон, сургалтад оролцогчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ. | 100% хэрэгжсэн. ЗӨСҮТ-ийн болон орон нутгийн мэргэжилтнүүдийг газар зүйн мэдээллийн системийн талаар мэдлэг олгон газар зүйн мэдээллийн системийн нэвтрүүлэн системийн программ, хангамжийн анхан болон ахисан түвшний сургалтыг зохион байгуулан дадлагажуулсан. Зоонозын өвчний тусгай зориулалтын атлас хийж, гарын авлага боловсруулсан. | 125,974,000.00 | 125,965,091.00 | 8,909.00 | 8,909.00 |
| 13 | АНУ Флоридагийн их сургууль, Монгол оронд тархсан зарим зүйлийн иксод хачгийн тархалт болон хачгаар дамжих халдварын үүсгэгчдийн хэв шинж, тархалтыг судлах | 2025.08.01-2025.12.31 | Монгол орны түгээмэл тархсан бэлчээрийн хачигand хачгаар дамжих зарим халдварын молекул биологийн шинжилгээ хийх. Молекул биологийн шинжилгээний зарим үр дүнг нэгтгэж олон улсын эрдэм шинжилгээний хурал, ном товхимолд нийтэлж бусад судлаач, эрдэмтдийн хүртээл болгох. | Төсөл хөтөлбөр 100% хэрэгжсэн. Монгол улсад тархсан зарим зүйлийн иксод хачгийн тархалт болон хачгаар дамжих халдварын үүсгэгчдийн хэв шинж, тархалтыг судлах ажлын хүрээнд Монгол орны зарим аймгийн нутаг дэвсгэрээс бэлчээрийн хачиг цуглуулж, зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хачгаар дамжих халдварын үүсгэгчдийг тодорхойлсон. | 44,922,375.00 | 44,585,355.00 | 337,020.00 | 337,020.00 |
| 14 | ДЭМБ, Yersinia-15 Олон улсын симпиозумыг зохион байгуулах | 2025.06.01-2025.10.31 | Тарваган тахал болон зоонозын бусад халдварууды үндэсний болон бүс нутгийн хэмжээнд хянахад олон улсын хэмжээнд нэг эрүүл мэнд үзэл баримтлалын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтран ажиллах байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл тодорхойлогдсон байна. | Төсөл хөтөлбөр 100% хэрэгжсэн. Монгол улс зоонозын халдварууд, ялангуяа тарваган тахал өвчний өндөр эрсдэлтэй бүс нутаг учраас хүн амыг эдгээр халдвараас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг сайжруулах, мэргэжлийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон. | 31,001,394.00 | 31,001,394.00 | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | ДЭМБ, Хөвсгөл аймагт бүртэгдсэн тарваган тахлын дэгдэлтийн хариу арга хэмжээний дараах үнэлгээ хийх | 2025.09.01-2025.12.31 | Хөвсгөл аймгийн Мөрөн суманд бүртгэгдсэн тарваган тахлын дэгдэлтийн хариу арга хэмжээний дараах үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх урт, дунд, богино хугацааны зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх. | Төсөл хөтөлбөр 100% хэрэгжсэн. Тарваган тахлын дэгдэлтийн хариу арга хэмжээний дараах үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан, ДЭМБ- аас гаргасан дэгдэлтийн дараах хариу арга хэмжээний үнэлгээний гарын авлагын дагуу үнэлгээний аргачлал боловсруулсан. Хөвсгөл болон үндэсний төвийн багаас байгалийн голомтын тандалт, тохиолдлын менежмент, тархвар судалгаа, тохиолдол, хавьтлын судалгаа, лаборатори, эмчилгээ, хариу арга хэмжээг үндэсний болон орон нутгийн түвшинд авах, урьдчилан илгээж, мэдээлэл ирэхэд ярилцлага хийсэн. Үнэлгээний нэгдсэн тайлан зөвлөмж боловсруулсан. Үнэлгээний дүнг хэлэлцүүлэн уулзалт зохион байгуулсан. | 38,683,600.00 | 38,683,600.00 | - | - |
| | **НИЙТ ДҮН** | | | | 1,336,577,081.50 | 1,275,261,312.50 | 61,315,769.00 | 345,929.00 |

Тайлан гаргасан:

Тооцооны нягтлан бодогч Ц.Дарьсүрэн